ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2021/17/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Сайншанд
2021 он


Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-Ulzii.t@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор: Ч.Ариунаа
Утас: 7052-3020 Цахим хаяг: Ariunaa.ch@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУ | Монгол Улс |
| ТАГ | Төрийн аудитын газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| БҮТЭААЭЗ | Бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйл |
| ТГТ | Төсвийн Гүйцэтгэлийн Тайлан |
| СҮДТ | Санхүүгийн Үр Дүнгийн Тайлан |

# Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .... 5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .... 5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .... 6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .... 8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .... 10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .... 12
3.Аудитын тайлан .... 13
3.1.Ерөнхий зүйл .... 13
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .... 13
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .... 13
3.4.Материаллаг байдал .... 14
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .... 14
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .... 15
3.7.Шилэн дансны мэдээлэл .... 16
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .... 16
3.9.Аудитын илрүүлэлт .... 16
Залруулсан алдаа .... 16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .... 16
Аудитын зөвлөмж .... 16
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .... 17
4.Менежментийн захидал .... 17
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .... 18

Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.25 № 1-6/119

танай ________ -ны № ________ -т

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА М.НАРАНДЭЛГЭР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газрын дарга 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 66,023,308.63 | 240,926,523.80 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - |
| 33 | АВЛАГА | 3,430,000.00 | 173,505,486.70 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 161,744,579.00 |
| 335 | Бусад авлага | 3,430,000.00 | 11,760,907.70 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 3,430,000.00 | 11,760,907.70 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 62,593,308.63 | 67,421,037.10 |
| 354 | Хангамжийн материал | 60,938,748.63 | 65,757,997.10 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,192,700.00 | 2,467,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 56,618,321.30 | 58,736,212.20 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,127,727.33 | 4,554,284.90 |
| 35600 | Мал амьтад | 1,654,560.00 | 1,663,040.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,636,108,771.22 | 2,462,642,597.27 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,636,108,771.22 | 2,462,642,597.27 |
| 392 | Биет хөрөнгө | 1,567,054,771.22 | 2,327,319,697.27 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 439,142,867.57 | 900,559,740.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (29,050,263.06) | (43,627,619.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 291,750,500.00 | 297,621,300.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (136,595,770.02) | (155,990,566.64) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 132,682,099.18 | 199,856,999.18 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (66,508,869.65) | (74,677,247.08) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 207,257,674.50 | 224,154,374.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (108,519,029.54) | (117,601,568.78) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 586,727,416.00 | 586,727,416.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (157,959,129.91) | (187,295,500.69) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 476,788,208.30 | 770,169,703.30 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (68,660,932.15) | (72,577,333.81) |
| 393 | Биет бус хөрөнгө | 69,054,000.00 | 135,322,900.00 |
| 39301 | Програм хангамж | 10,577,264.00 | 12,563,264.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (9,977,264.00) | (10,052,264.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 68,454,000.00 | 132,811,900.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,702,132,079.85 | 2,703,569,121.07 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 162,794,579.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 162,794,579.00 |
| 413 | Өглөг | - | 162,794,579.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 161,744,579.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 1,050,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 1,050,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,702,132,079.85 | 2,540,774,542.07 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,702,132,079.85 | 2,540,774,542.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,170,529,816.54 | 1,170,529,816.54 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 403,468,789.10 | 1,242,111,251.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 403,468,789.10 | 403,468,789.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 838,642,462.22 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 128,133,474.21 | 128,133,474.21 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,702,132,079.85 | 2,703,569,121.07 |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 744,105,984.00 | 1,489,284,374.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 344,318,327.00 | 592,956,369.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 344,318,327.00 | 592,956,369.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 344,318,327.00 | 1,122,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 837,150.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,122,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 343,481,177.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -ҮХ | | 586,933,369.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -БМ | | 4,901,000.00 |
| 141001 | Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр | | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 399,787,657.00 | 896,328,005.70 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 349,517,900.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 349,517,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 50,269,757.00 | 457,985,105.70 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,590,000.00 | 249,975,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 45,679,757.00 | 208,009,505.70 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 438,342,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 438,342,900.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 517,952,776.30 | 592,195,312.48 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 517,952,776.30 | 592,195,312.48 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 515,915,934.10 | 579,956,437.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 222,064,441.00 | 237,168,064.00 |
| 210101 | Үндсэн цалин | 215,344,441.00 | 222,679,953.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,720,000.00 | 14,488,111.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,736,060.00 | 29,928,481.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,624,708.00 | 21,109,351.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,060,344.00 | 2,471,762.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,850,995.00 | 1,886,739.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 381,827.00 | 407,148.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,818,186.00 | 4,053,481.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,017,781.00 | 29,810,955.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,701,761.00 | 11,500,197.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,316,020.00 | 18,283,758.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 27,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 37,558,814.80 | 51,028,347.53 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,098,050.00 | 5,358,310.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,767,049.00 | 21,657,696.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,993,000.80 | 2,551,940.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 209,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 228,300.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,172,415.00 | 6,842,230.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 14,168,771.53 |
| 2105 | Нормативт зардал | 45,250.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 45,250.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,598,605.00 | 4,534,570.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,598,605.00 | 4,534,570.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,894,994.00 | 3,623,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,894,994.00 | 3,623,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 56,260,690.00 | 134,641,478.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 55,350,184.00 | 131,641,162.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 230,000.00 | 576,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 259,506.00 | 1,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 281,000.00 | 656,282.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 140,000.00 | 250,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | - | 518,034.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 136,739,298.30 | 89,220,841.95 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,005,000.00 | 4,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 139,000.00 | 170,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 134,595,298.30 | 84,550,841.95 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,036,842.20 | 12,238,875.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 800,000.00 | 2,300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 2,300,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,236,842.20 | 9,938,875.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,236,842.20 | 9,938,875.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 226,153,207.70 | 897,089,062.22 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 445,800.00 | - |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 445,800.00 | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 451,848.09 | 58,446,600.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 451,848.09 | 3,181,167.59 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 55,265,432.41 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (6,048.09) | (58,446,600.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 226,147,159.61 | 838,642,462.22 |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 400,637,486.00 | 739,135,426.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 849,829.00 | 1,122,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 849,829.00 | 1,122,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 849,829.00 | 1,122,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 849,829.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,122,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 399,787,657.00 | 738,013,426.70 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 349,517,900.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 349,517,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 50,269,757.00 | 299,670,526.70 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 45,679,757.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,590,000.00 | 249,975,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 49,694,926.70 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 438,342,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 438,342,900.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 380,784,301.00 | 518,282,106.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 380,784,301.00 | 518,282,106.70 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 375,317,458.80 | 494,282,324.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 221,508,700.00 | 237,168,064.00 |
| 210101 | Үндсэн цалин | 214,788,700.00 | 222,679,953.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,720,000.00 | 14,488,111.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,581,104.00 | 29,928,481.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,372,004.00 | 20,808,924.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,052,200.00 | 2,387,517.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,641,900.00 | 1,925,001.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 410,400.00 | 438,894.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,104,600.00 | 4,368,145.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,477,781.00 | 29,810,955.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,701,761.00 | 11,500,197.00 |
| 210302 | Түлш, халаалт | 776,020.00 | 18,283,758.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 27,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,070,319.80 | 27,969,636.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,409,800.00 | 6,744,110.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,220,699.00 | 16,082,376.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,913,300.80 | 2,998,440.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 209,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 228,300.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 998,220.00 | 1,695,310.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,494,450.00 | 298,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,494,450.00 | 298,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,409,750.00 | 8,168,790.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,691,370.00 | 2,550,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,718,380.00 | 5,618,790.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,894,994.00 | 3,623,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,894,994.00 | 3,623,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 61,301,160.00 | 148,650,198.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 60,390,654.00 | 145,649,882.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 230,000.00 | 576,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 259,506.00 | 1,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 281,000.00 | 656,282.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 140,000.00 | 250,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 518,034.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,579,200.00 | 8,664,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,199,200.00 | 8,494,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,380,000.00 | 170,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,466,842.20 | 23,999,782.70 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 800,000.00 | 2,300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 2,300,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,666,842.20 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,666,842.20 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 21,699,782.70 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9,938,875.00 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 11,760,907.70 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 19,853,185.00 | 220,853,320.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 19,853,185.00 | 220,853,320.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 19,853,185.00 | 220,853,320.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 19,853,185.00 | 220,853,320.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 19,853,185.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 220,853,320.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (19,853,185.00) | (220,853,320.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,170,529,816.54 | 128,133,474.21 | 177,321,629.49 | 1,475,984,920.24 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,170,529,816.54 | 128,133,474.21 | 177,321,629.49 | 1,475,984,920.24 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 226,147,159.61 | 226,147,159.61 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,170,529,816.54 | 128,133,474.21 | 403,468,789.10 | 1,702,132,079.85 |
| D01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,170,529,816.54 | 128,133,474.21 | 403,468,789.10 | 1,702,132,079.85 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,170,529,816.54 | 128,133,474.21 | 403,468,789.10 | 1,702,132,079.85 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 838,642,462.22 | 838,642,462.22 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,170,529,816.54 | 128,133,474.21 | 1,242,111,251.32 | 2,540,774,542.07 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 462,166,600.00 | 429,526,025.00 | 32,640,575.00 | 92.94 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 462,166,600.00 | 429,526,025.00 | 32,640,575.00 | 92.94 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 461,366,600.00 | 428,726,025.00 | 32,640,575.00 | 92.93 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 261,987,200.00 | 237,168,064.00 | 24,819,136.00 | 90.53 |
| 210101 | Үндсэн цалин | 246,867,200.00 | 222,679,953.00 | 24,187,247.00 | 90.20 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,120,000.00 | 14,488,111.00 | 631,889.00 | 95.82 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 32,900,000.00 | 29,928,481.00 | 2,971,519.00 | 90.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,420,500.00 | 20,808,924.00 | 1,611,576.00 | 92.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,619,900.00 | 2,387,517.00 | 232,383.00 | 91.13 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,096,000.00 | 1,925,001.00 | 170,999.00 | 91.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 523,900.00 | 438,894.00 | 85,006.00 | 83.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,239,700.00 | 4,368,145.00 | 871,555.00 | 83.37 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 30,795,000.00 | 29,810,955.00 | 984,045.00 | 96.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,200,000.00 | 11,500,197.00 | 699,803.00 | 94.26 |
| 210302 | Түлш, халаалт | 18,464,500.00 | 18,283,758.00 | 180,742.00 | 99.02 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 130,500.00 | 27,000.00 | 103,500.00 | 20.69 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,373,500.00 | 24,996,560.00 | 2,376,940.00 | 91.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,700,000.00 | 6,669,110.00 | 30,890.00 | 99.54 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,589,500.00 | 13,370,600.00 | 2,218,900.00 | 85.77 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,844,000.00 | 2,812,140.00 | 31,860.00 | 98.88 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 209,400.00 | 90,600.00 | 69.80 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 240,000.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,700,000.00 | 1,695,310.00 | 4,690.00 | 99.72 |
| 2105 | Нормативт зардал | 300,000.00 | 298,500.00 | 1,500.00 | 99.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 300,000.00 | 298,500.00 | 1,500.00 | 99.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 78,293,100.00 | 78,196,299.00 | 96,801.00 | 99.88 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,000,000.00 | 7,000,000.00 | - | 100.00 |
| 210602 | Тавилга | 24,793,100.00 | 24,731,000.00 | 62,100.00 | 99.75 |
| 210604 | Урсгал засвар | 46,500,000.00 | 46,465,299.00 | 34,701.00 | 99.93 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,803,000.00 | 2,593,700.00 | 209,300.00 | 92.53 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,803,000.00 | 2,593,700.00 | 209,300.00 | 92.53 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21,244,800.00 | 20,563,466.00 | 681,334.00 | 96.79 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,128,800.00 | 17,563,150.00 | 565,650.00 | 96.88 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 576,000.00 | - | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 756,000.00 | 656,282.00 | 99,718.00 | 86.81 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 250,000.00 | 250,000.00 | - | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 534,000.00 | 518,034.00 | 15,966.00 | 97.01 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,670,000.00 | 5,170,000.00 | 500,000.00 | 91.18 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 670,000.00 | 170,000.00 | 500,000.00 | 25.37 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 800,000.00 | 800,000.00 | - | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 800,000.00 | 800,000.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 800,000.00 | - | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 462,166,600.00 | 439,464,900.00 | 22,701,700.00 | 95.09 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 461,166,600.00 | 438,342,900.00 | 22,823,700.00 | 95.05 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 461,166,600.00 | 438,342,900.00 | 22,823,700.00 | 95.05 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,000,000.00 | 1,122,000.00 | (122,000.00) | 112.20 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,122,000.00 | (122,000.00) | 112.20 |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0 | 287,909,619.00 | (287,909,619.00) |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 0 | 287,909,619.00 | (287,909,619.00) |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0 | 286,409,619.00 | (286,409,619.00) |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 0 | 2,973,076.00 | (2,973,076.00) |
| 210401 | Бичиг хэрэг | 0 | 75,000.00 | (75,000.00) |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0 | 2,711,776.00 | (2,711,776.00) |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0 | 186,300.00 | (186,300.00) |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 0 | 2,550,000.00 | (2,550,000.00) |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 2,550,000.00 | (2,550,000.00) |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0 | 1,030,000.00 | (1,030,000.00) |
| 210702 | Дотоод албан томилолт | 0 | 1,030,000.00 | (1,030,000.00) |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 0 | 276,362,543.00 | (276,362,543.00) |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0 | 276,362,543.00 | (276,362,543.00) |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0 | 3,494,000.00 | (3,494,000.00) |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0 | 3,494,000.00 | (3,494,000.00) |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0 | 1,500,000.00 | (1,500,000.00) |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0 | 1,500,000.00 | (1,500,000.00) |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0 | 1,500,000.00 | (1,500,000.00) |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0 | 299,670,526.70 | (299,670,526.70) |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0 | 299,670,526.70 | (299,670,526.70) |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 249,975,600.00 | (249,975,600.00) |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0 | 49,694,926.70 | (49,694,926.70) |

## 3 Аудитын тайлан

### 3.1. Оршил

МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сумын ЗДТГ-ын дарга М.Нарандэлгэр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021.02.17-оос 2021.02.19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аймаг дахь ТАГ-ын ахлах аудитор Ч.Ариунаа хариуцаж хэрэгжүүлэв.

Даланжаргалан сумын ЗДТГ нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.01.20-ны өдрийн 03/30 дугаар бүхий албан бичгээр 2021.01.22-ны өдөр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Даланжаргалан сумын ЗДТГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас тайлант хугацаанд тус байгууллагад хяналт, шалгалт хийгдээгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны ТГТ-ын тайлангийн батлагдсан төсвийн дүн 464,499.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,644.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчиллөө.

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны нийт зардал 650,641.9 мянган төгрөг бөгөөд түүний *1* хувь болох 6,506.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,001,437.0 мянган төгрөгөөр буюу 58,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | |
| Авлага | 3,430.0 | 173,505.5 | 170,075.5 |
| Бараа материал | 62,593.3 | 67,421.0 | 4,827.7 |
| Үндсэн хөрөнгө | 1,636,108.8 | 2,462,642.6 | 826,533.8 |
| **Нийт хөрөнгө** | 1,702,132.1 | 2,703,569.1 | 1,001,437.0 |
| Өр төлбөр | 0 | 162,794.,6 | 162,794.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,702,132.1 | 2,540,774.5 | 838,642.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,702,132.1 | 2,703,569.1 | 1,001,437.0 |

Авлага дансны үлдэгдэл 173,505.5 мянган төгрөг болж 170,075.5 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар тус сумын ЗДТГ-ын барилгын засварын ажил хийгдсэн бөгөөд 161,744.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан, мөн нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 11,760.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 67,421.0 мянган төгрөг болж 4,827.7 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, мал амьтадын үлдэгдэл өссөн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,462,642.6 мянган төгрөг болж 826,533.8 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн дансанд 32,181.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 937,350.3 мянган төгрөг тус тус нэмэгдэж, 58,446.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, элэгдлийн зардалд 84,550.,8 мянган төгрөгийг бүртгэсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 162,794.6 мянган төгрөг болж, тус дүнгээр өссөн нь сумын ЗДТГ-ын засварын ажлын дутуу олгосон санхүүжилтийн 161,744.6 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 1,050.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,540,774.5 мянган төгрөг болж 838,642.4 мянган төгрөгөөр өссөн нь үр дүнгийн тайлангийн өөрчлөлт нөлөөлжээ.

Даланжаргалан сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 745,178.4 мянган төгрөгөөр буюу 100,1 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 137,497.8 мянган төгрөгөөр буюу 36,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлсний зардал байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг туслах үйл ажиллагааны орлого 1,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 587,046.2 мянган төгрөг, нийт 588,046.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 588,046.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 125,879.6 мянган төгрөгөөр хасагдуулж, 462,166.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 462,166.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 461,166.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 438,342.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 1,122.0 мянган төгрөг, нийт 439,464.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 439,464.9 мянган төгрөгийг зарцуулж 9,938.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 439,464.9 мянган төгрөг буюу 95,1 хувьтай байгаа нь орон нутгийн төсвийн санхүүжилтийг 22,823.7 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 249,975.6 мянган төгрөгийг хуваарилж, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 49,694.9 мянган төгрөгийг бүрдүүлж, 276,148.7 мянган төгрөгийг зарцуулж, 11,760.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, 5 мэдээллийг хугацаа хоцроож, 142 мэдээллийг хугацаанд нь оруулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | | | | | | | |
| Зөвлөмж | 1 | - | 1 | - | - | | |
| Нийт дүн | 1 | | 1 | | | | |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,010.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс, 3,430.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 580.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Өмнөх оны нэмэлт санхүүжилтийн авлага 3,430.0 мянган төгрөгийг барагдуулсныг тухайн оны орлогоор бүртгэснийг СҮДТ-нд залруулга хийсэн.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

1. БҮТЭАА ЭЗүйлс зардлын данснаас 580.0 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авсан Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан зардлын эдийн асгийн ангиллыг зөрчиж, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илрүүлсэн 152,611.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх  анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4.Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд мал амьтадын бүртгэлд хурга, төлөг, нийт 9 толгой малыг нас дэвшүүлж бүртгээгүй байна.

4.1.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

4.1.3 Зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгож, малын нас дэвшилтийг бүрэн бүртгэж, мал амьтдын тайланг үнэн зөв гаргаж байх.

4.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 67 нэр төрлийн 152,611.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.

4.2.2 Эрсдэл

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

4.2.3 Зөвлөмж

Ашиглах боломжтой боловч ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг үнэлж бүртгэх, шаардлага хангаагүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Даланжаргалан сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | ДГА-2021/17/СТА- ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Даланжаргалан сумын ЗДТГ | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тайлант онд мал амьтадын бүртгэлд хурга, төлөг, нийт 9 толгой малыг нас дэвшүүлж бүртгээгүй байна. | 0,0 | Зөвлөмж өгөх | Сумын ЗДТГ-ын эд хариуцагч, нягтлан бодогч | Бат-Оюун |
| 2 | Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 67 нэр төрлийн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна. | 0,0 | Зөвлөмж өгөх | Сумын ЗДТГ-ын ӨХБЗөвлөл | Бат-Оюун |
| 3 | БҮТЭАЗЗүйлс зардлын данснаас 580.0 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авсан. | 580,0 | Албан шаардлага өгөх | Сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Бат-Оюун |
| 4 | Өмнөх оны нэмэлт санхүүжилтийн авлага 3,430.0 мянган төгрөгийг барагдуулсныг тухайн оны орлогоор бүртгэсэн. | 3,430.0 | Залруулсан | Сумын ЗДТГ-ын нягтлан бодогч | Бат-Оюун |
| **ДҮН** | | **4,010.0** | | | |